


Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын танилцуулга материал

1. Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, онцлогийн талаар



Өмнөдэлгэр сум нь хойд талаараа ОХУ, баруун хойд талаараа Цэнхэрмандал, Төв аймгийн Мөнгөнморьт, зүүн болон зүүн хойд талаараа Хэрлэн, Жаргалтхаан сумдуудтай хиллэдэг. Улаанбаатар хотоос 300км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос 110км алслагдсан ба 1088989,2 мянга нутаг дэвсгэртэй, Монголын ой тал хээр хосолсон Хэнтий нурууны уулархаг нутгийн урд хэсэгт оршино

Нийт газар нутаг 1087652га

Үүнээс:

Ойн сан бүхий газар 183288га

Улсын тусгай хэрэгцээний газар 350599 га

ХАА-ын газар 549149га


Хот, тосгоны суурин газар 673,6га


Зам, шугам сүлжээний газар 1978,4га

Усны сан бүхий газар 1964га

2. Хүн амын тоо, яс үндэс, соёл, уламжлал, ёс заншлын онцлогийн талаар.

Нийт хүн амын тоог графикаар үзүүлвэл





3. Сумын брэнд бүтээгдэхүүн, түүний онцлогийн талаар

1. Нүнжиг цагаан идээ



Сүүг уламжлалт аргаар боловсруулан сүүн, сүүн бүтээгдэхүүн боловсруулан ард иргэдийг цэвэр бүтээгдэхүүнээр хангаж байна. Нүнжиг идээ нь Хэнтий аймаг төдийгүй зүүн бүс, улсын хэмжээний үзэсгэлэн худалдаануудад амьжилттай оролцож сум, аймгийнхаа нэрийг гарган шалгардаг брэнд бүтээгдэхүүн юм.

2. Зөгийн бал

Өмнөдэлгэр суманд 2 өрх зөгийн аж ахуй эрхлэж байгаа бөгөөд Наран, Баянзүрх, Хэнтий багийн нутагт оторлох замаар цэцгийн тоос цуглуулан жилд 6 тн цэвэр зөгийн балыг боловсруулан орон нутаг болон аймгийн төвийн ард иргэдийн хэрэгцээг ханган ажиллаж байна.



4. Манай суманд 7 багийн 1245 малтай өрхтэй үүнээс малчин 891, 1616 малчин мал аж ахуйн салбарт ажиллаж байна. 506843,74 га бэлчээрийн талбайд 484966 толгой мал маллан аж төрж байна. Тус сум 2015, 2016 онуудад хамгийн олон мал тоолуулсан сумаар шалгарч байсан.



5. Амьтан, ургамлын аймаг, төрөл зүйл, ангиллын талаар



Монгол орны ургамал-газар зүйн мужлалаар тус сумын нутаг ургамлан нөмрөг, ургамшлын хувьд Хэнтийн уулын тайгын тойрог, Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт байршдаг, төрөл зүйлийн хувьд нэн баялаг. Энэ нутгийн ургамлан нөмрөг,



ургамшлын ерөнхий шинж төрх нь уулсын өндөр, нам, газрын гадаргуугын байдалтай уялдан ойт хээр, хээрийн бүсийн ургамал холилдон олон янз хэв шинжийг үүсгэдэг онцлогтой. Бэсрэг уулс, толгодын орой, энгэрээр жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, хялана-алаг өвст, биелэг-алаг өвст, зүр өвс-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-бутнуур-алаг өвст, бутууль-алаг өвст бүлгэмдэл өргөн тархажээ. Эдгээр бүлгэмдэлд: сибирь Зүр өвс, хонин Ботууль, сунагар Биелэг, Крыловын Хялгана, Том цэцэгт Дааган сүүл, алтайн Гол гэсэр, үлд өвс, хоёр ишт Бэриш, жинхэнэ Өрөмтүүл, Навтуул, говийн Ганга зонхилон тохиолдоно.



Уулын ар, чийглэг хажуугаар Даль, Тэрэлж, Боролзгоно, Бургас зэрэг хангайн сөөг элбэг ургахаас гадна зүйл зүйлийн Улалж, Цагаан суль, Согоовор, эмийн Сөд, Сараана, сибирь Хонхлой, Унаган туруу, азийн Жамъянмядаг, Алирс, Нэрс, Бугын цагаан, Цээнэ, Бамбай зэрэг ургамал ургах ба бэлчээр хадлангийн гол хэвшинжийг үүсгэнэ.

Уул хоороны хөндий, хоолойгоор Өлөнгө, Согоовор, Дурваалиг, Улаан толгой, Сөд, Цөс өвс, орос Чирэг, Улалж, Мэхээр, Мягмансанж, Бэр цэцэг, Бэриш, Өрөмтүүл, Башир, Хурган чих, Яргуй, Гишүүнэ зэрэг ургамал голлох бөгөөд жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, алаг өвс-үетэнт, хиаг-алаг өвст хялгана-алаг өвст төрлүүд үүсгэнэ. Нутгийнхны ахуй амьдралдаа өргөн хэрэглэдэг хад,тэхийн шээг,нэрс,улаалзгана,үхэрнүд,гүзээлзгэнэ,нохойнхошуу зэрэг жимс жимсгэнэ,сөд өвс ,булган өвс, алтанзул, цагаан дэгд, чихэр өвс,цагаан төмс , гишүүнэ,мангир, жууцай бах өвсзэрэг эмийнболон ахуйн хэрэгцээний ургамал элбэг ургадаг онцлогтой.

Нутгийнхны ахуй амьдралдаа өргөн хэрэглэдэг хад,тэхийн шээг,нэрс,улаалзгана,үхэрнүд,гүзээлзгэнэ,нохойнхошуу зэрэг жимс жимсгэнэ,сөд өвс ,булган өвс, алтанзул, цагаан дэгд, чихэр өвс,цагаан төмс , гишүүнэ,мангир, жууцай бах өвс зэрэг эмийн болон ахуйн хэрэгцээний ургамал элбэг ургадаг болно..

Амьтан

Тус орчны бүсэд 40 гаруй зүйлийн хөхтөн тэмдэглэгдсэнээс ердийн буюу хэвийн үзэгдэлд 26,ховордуу 6, маш ховор буюу хааяа үзэгддэг 8 зүйл тархсан. Үүний зонхилох хувийг мэрэгч,махчин амьтан эзэлдэг бөгөөд үлдсэн хэсгийг салаа туурайтан, туулай хэлбэртэн эзэлдэг.Уламжлалт агнуурын ач холбогдолтой таварга,чоно,, зээр элбэг тохиолддог. Нийт нутгаар болон ус намгархаг газруудаар суурин болон нүүдлийн амьдралтай шувууд олон байдаг. Тухайлбал Цэн тогоруу, ангир, хун, тоодог, өөвөлж, хөх

цэцгий, элээ, хэрээ, шар шувуу, ууль, тоншуул, оронгийн болжмор, тагтаа, шаазгай, хараацай шувууд байдаг.

Зэрлэг гахай



Бор гөрөөс



Буга



Үнэг



Чоно



Хандгай



6. Түүхэн дурсгалт газрууд



Врайбун хийд, Хүүхэн хутагтын буган чулуунууд зэрэг олон арван түүхийн улбаа шингэсэн дурсгалт газруудтай. Монгол оронд 1777 оны гал тахиа жил Балдан Врайбун хийдийн анхны Шар сүмийг барьсан түүхтэй.

Манай сүм нь Төрийн их тахилгат эзэн Чингис хааны өлгий Бурхан Халдун уул, Арван чулуун бурханаар хүрээлүүлсэн Ар Халхын Утай Цагаан гүмбэн хэмээн нэрлэгдсэн Балдан хийд, Эртний сүг зураг бүхий



Өмнөдэлгэр сумын Баянзүрх багийн нутагт, сумын төвөөс хойд зүгт 70 км-т, Мөнх-Өлзийт уулын энгэрт Ар Халхын цагаан Утай гэгдэх Балдан Врайбун хийдийн сэргээсэн дугана, түүний эргэн тойронд хаданд сийлсэн бурхад, барилга байгууламжийн үлдэгдэл байна.

Уг хийд 214 гаруй жилийн хугацаанд цэцэглэн хөгжиж, 3000-5000 ламтай, лам, нар, худалдаачин наймаачны хороололтой 30 гаруй дугантай байжээ. Эргэн тойрных нь ууланд байгаль эхээс заяасан үзэсгэлэнт тогтоц, ургаа хад чулууг ашиглан 10 чулуун бурхан, ном судар, бичээс, соёмбо урлаж,

1784 оны намрын адаг сарын билэгт сайн өдөр “Арван чулуун бурхнаар хүрээлүүлсэн Ар Халхын цагаан УтайГүмбүм” хэмээн алдаршсан билээ.. 1938 онд түүнийг хэлмэгдлийн хар сүүдэр дайрч, гол цогчин сүмийн барилгыг бүрэн устгаж чадалгүй орхиж байсан түүхтэй. 2009-2010 онд Тус хийдийн гол дуган Билэг Өлзийт сүмийг сэргээн засварлаж ашиглалтад оруулсан. 2017 онд тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж жил бүрийн 8 дугаар сард Балдан Врайбун хийдийн буяны бүтээлийн хурал хурж сүсэгтэн олны буяныг арвижуулдаг сайхан уламжлалтай.



ОН



1923 он



Өмнөдэлгэр сумын Баянзүрх багийн нутагт сумын төвөөс баруун хойд зүгт 180 км-т Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар нутагт Бурхан Халдун уул оршино. Бурхан Халдун ууланд Дээд, дунд, доод гэх 3 тахилгат овоо байх агаад тэдгээрийг чулуун овоолон босгосон байна. Эзэн Чингисийн үеэс өнөөг хүртэл тахин шүтэж, хайрлан хамгаалж ирсэн уул усны нэг бол Бурхан Халдун уул юм. Уг уулын төрийн тахилгыг Монгол улсын ерөнхийлөгчийн зарилгаар 1995 оноос эхлэн дөрвөн жил тутамд тахиж байхаар болсон бөгөөд 2013 онд МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол төрийн бахархалаар тодруулсан билээ. 2015 онд Бурхан Халдун уул, түүний

орчмын тахилгат газар нутаг нь Юнеско-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн.

Олон өвчнийг анагаах шидтэй ононгийн халуун рашаан

XVII зууны үед рашааны дэргэд 60 орчим маарамба ламтай Наваанжалба гэдэг байнга хурал хурдаг дуган байжээ. Нэг өвөлд 600-1200 орчим хүн ирж бараалхан биеэ ариусган өвчнөө засдаг байв. Эл рашаанд Анхдугаар Богд Занабазар, Халхын Сэцэн хан Шолой, Халхын зая бандида Лувсанпэрэнлэй, Аграмба Нанзаддорж зэрэг түүхэн хүмүүс бараалхан ирж ордог байсан түүхтэй. Уг рашаан нь хүхэрт устөрөгч хийн үнэртэй, өнгөгүй тунгалаг рашаан бөгөөд нийт 24 ундаргатай, тус бүр 14-98 хэмийн халуунтай. 1921-1941 онд Оросын эрдэмтэн М.А.Усов, 1958-1960 онд Монголын эрдэмтэд судлаад эл рашаан нь үе мөчний архаг хууч, мэдрэлийн элдэв өвчнийг анагаахад үр нөлөөтэй хэмээн тэмдэглэжээ. Олон жилийн ажиглалт, өвчнөө сувилсан хүмүүсийн яриа, дурсамж тэмдэглэлээс үзвэл Ононгийн халуун рашаан нь үе мөчний үрэвсэл, бөөрний даралт, бруцеллёз, цусны даралт, хамуу болон арьс өнгөний төрлийн өвчнүүд, шижин, шар ус, хуян зэрэг өвчинг анагаан эдгэрүүлэх увидастай хэмээн үздэг.



Хүүхэн хутагтын хүрээний туурь



Цэцэн хан аймгийн Мэргэн гүнийн хошуунд Энх-Амгаалангийн 44 дүгээр он 1705-д Өндөр гэгээн, Далай цэцэнхан тэргүүтэн их, бага дуган,сүм байгуулан түй мандал өргөжээ.1910–аад оны үеэс Хүүхэн хутагтын хүрээ гэж нэрлэгдэх болсон. Хүүхэн хутагтын хүрээ нь 1937 он хүртэл хурал ном, бусдад буян үйлдэх ажлаа таслаагүй үргэлжлүүлж байжээ. Тус хүрээ нь 10 дацан, 6 аймаг,26 дуган, 4 сүм суварга, 22 жас, 700 гаруй ламтай үйл ажиллагаа явуулж байв. Одоогоор барилга байгууламжийн үлдэгдэл 10 гаруй, 50 орчим гэрийн чулуун буурь /4-10 ханатай гэрийн бууриуд/,10 гаруй суварганы суурь байдаг.

Дунд жаргалантын буган хөшөө



Өмнөдэлгэр сумын Баянзүрх багийн нутагт, сумын төвөөс хойд зүгт 30 гаруй км-т,



Жаргалантын голын хойд хөндий, Билүүтийн ам хэмээх МНТ-д бичигдсэн “Айл харгана” хэмээх газар буган хөшөө, дөрвөлжин булш, хиргисүүр бүхий цогцолбор дурсгал бий. Энд нийт 2 хиргисүүр, 22 дөрвөлжин булш, 5 буган чулуун хөшөө, 2 тахилын онгон байна.

1-р буган хөшөө: /хамгийн урд талын/ энэ буган хөшөөг саарал өнгийн боржин чулуугаар үйлджээ. Хөшөөний эргэн тойронд 7 бугыг загварчилсан байдлаар баруун дээш тэмүүлж байгаагаар дүрсэлжээ. Бугануудын доод хэсгээр хөшөөг эргэн тойрон хоёр шулуун зураас тойруулж шулуун зураасаар хөндлөн огтолсон бүс дүрсэлжээ. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт хүний нүүрийг товойлгон дүрсэлсэн нь эдүгээ тал хэсэг нь л харагдана. Хойд талын дээд хэсэгт багавтар цагираг, зүүн хажууд бамбай гэх тагнай хээ бүхий дүрслэлийг цохиж урлажээ. /Солбилцол№-1/

2-р буган хөшөө: /нүүртэй хөшөөний ар талд бий/ энэ буган хөшөөг мөн л саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн байна. Хөшөөг зэрэгцээ 5 бугаар ороолгон түүний доод хэсэгт зэрэгцээ олон босоо зураас бүхий бүсийг бүтэн ороолгон дүрсэлжээ. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт багавтар цагираг дүрсэлсэн./Солбилцол№-2/

3-р буган хөшөө: /цогцолборын хойд хэсэгт орших хоёр хөшөөний урд талынх нь/ энэ хөшөөг хөх саарал өнгийн гантиг чулуугаар үйлдсэн ажээ. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт цагираг, түүний доогуур зүүн тээш татсан /хөшөөний толгой хэсгийг бүтэн ороосон/ шулуун зураас, түүний доод хэсэгт 7 бугыг /дээд талын хоёр бугыг баруун доош хандуулан

дүрсэлсэн байна/ зүүн дээш тэмүүлж байгаагаар дүрсэлжээ. Мөн тольтой кинжаал хутга, саадаг зэргийг дүрсэлжээ. Хөшөөний зүүн талын дунд хэрд тагнай хээ бүхий дүрс /бамбай/ ар талд байлдааны зээтүүг тус тус дүрсэлсэн байна. Хөшөөний доод хэсгээр хурц өнцөгтэй дан гурвалжин хээ татсан байдаг. /Солбилцол№-3/

4-р буган хөшөө: /цогцолборын хамгийн хойд талд байна. Энэ хөшөөг саарал өнгийн боржин чулуугаар үйлджээ. Хөшөөний баруун зүүн хажуугийн дүрслэл элэгдэж үзэгдэхгүй болсон. Хөшөөний ар талын толгойн хэсэгт цагираг /нар/ түүний дор нэг буга, нүүрэн талын дээд хэсэгт цагираг, нар нум /сар/ сийлж түүний доогуур нарийхан шулуун зураас гаргажээ. Түүний доод хэсэгт хоёр бугыг доош хандсан, 4 бугыг дээш дүүлж байгаагаар дүрсэлсэн байна. Дээрх бугыг бүгдийг нь сонгодог аргаар загварчлан дүрсэлсэн байна. /Солбилцол№-3/

5-р буган хөшөө: / буган чулуун хөшөөн нь цогцолборын баруун хойш оршино/ энэ хөшөөг мөн л саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн аж. Хөшөөний нүүрэн талын дээд хэсэгт цагираг, түүний доод хэсэгт хөшөөг бүтэн тойрсон хөндлөн дан зураас түүний доод хэсгээр хөрөөний ир мэт дүрсийг бүс байдлаар тус тус дүрсэлжээ. Хөшөөний баруун зүүн талд чухам ямар дүрс байгаа нь мэдэгдэхгүй болсон байна. Хөшөөний ар талын дээ хэсэгт жижиг буга, түүний доод хэсэгт баруун дээш дүүлж байгаа 4 бугыг сонгодог аргаар дүрсэлсэн байдаг.

ХАНГАЛ НУУР

Хангал нуур нь Хэнтийн нурууны зүүн өмнөд хэсэгт орших бөгөөд ойт хээрийн бүсэнд Хурхын гол , түүний цутгал Жаргалант гол хоёрын хооронд оршдог байгалийн үзэсгэлэнт газар юм.

Энэ нуур нь ойт хээрийн бүсэд орших томоохон нуур төдийгүй бусад нууруудыг бодвол усны горимын хувьд нилээд тогтвортой гэж үзэж болно. Эргэн тойрон хадтай уулсаар хүрээлэгдэн 1326 м үнэмлэхүйн өндөрт орших энэхүү нуур тектоникийн хонхорт тогтож, хамгийн урт нь хоёр км, өргөн нь 500-1200 м, талбай нь 1.5 хавтгай дөрвөлжин километрт хүрдэг. Баян голоор Хурх голтой холбогддо,загастай,намгийн шувууд ихтэй. Нуурын ойролцоо Баянгол жуулчны бааз бий.



Хангал нуурын дэргэд байрлах буга согооны хөшөө



7. Байгалийн баялаг, ашигт малтмалын орд газрын тухай

Алтны орд бүхий газрууд, өнгөт металл, мөнгө, цайр тугалга, шохойн чулууны орд газруудтай.

8. Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэлийн талаар.

Тахианы аж ахуй

6-р багийн иргэн Б.Батчулуун нь 2011 онд сум хөгжүүлэх сангаас зээл 7,0 сая төгрөгийн зээл авч 40 өндөглөгч тахиа, 5 цацагт хяруул авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2017 оны байдлаар 80 гаруй тахиатай, 12 цацагт хяруултай. Үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.



Зөгийн аж ахуй

Д.Цэцэгмаа сум хөгжүүлэх зээлд хамрагдаж 2014 оноос зөгийн аж ахуйг эрхэлж орон нутгийн Наран, Баянзүрх, Хэнтий багийн нутагт оторлох замаар цэцгийн тоос цуглуулан жилд 6 тн цэвэр зөгийн балыг боловсрууладаг. Орон нутаг болон аймгийн төвийн ард иргэдийг эрүүл боловсруулаагүй цэвэр зөгийн балаар ханган ажиллаж байна.





Г.Баатархүү хувиараа хөдөлмөр эрхлэгч 2015 онд сум хөгжүүлэх зээлд хамрагдаж байгалийн чулуугаар гар хийцний хөөрөг хийх үйл ажиллагааг эрхлэдэг.



Хувиараа хөдөлмөр эрхлэгч И.Түвшинбаатар 2015 онд Сум хөгжүүлэх сангын зээлд хамрагдаж буйдан хийх, хуучин буйданг сэргээн засварлах үйл ажиллагааг эрхлэж байна.



Хувиараа хөдөлмөр эрхлэгч Н.Гомбо хувиараа хөдөлмөр эрхлэгч 2011 онд Сум хөгжүүлэх сангын зээлд хамрагдсан. Мод модон материалыг ашиглан гэрийн мод, тавилга хийж сумын ард иргэдийн хэрэгцээг ханган ажиллаж байна.





“Дэлгэрхангай” гутал захиалга засвар 2006 оноос одоог хүртэл эхлэн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.



Сумын хэмжээнд талх, нарийн боов, тортны үйлчилгээг эрхэлдэг 2 аж ахуй нэгж, 7 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн үйл ажиллагаагаа тогтмол явуулж иргэдийг чанарын шаардлага хангасан эрүүл хүнсээр хангаж байна.



9.Цаашид хөгжүүлэх боломжтой үйлдвэрлэл үйлчилгээ сумын хэтийн хөгжлийн төлөвийн талаар

Манай сум нь хүн ам олонтой, иргэдийн амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийн тоо толгой жил тутам өсч, байгаатай холбогдуулан түүнээс гарах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор мах, сүүний чиглэлийн аж ахуйг нэмэгдүүлж өндөр ашиг шимтэй мах, сүүний бэлчээр хосолсон ферм байгуулж “ Монгол фермер” төслийг эхлүүлэхээр газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зарлаад байна. Жижиг дунд үйлдвэрлэл болон, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн санал санаачлагыг дэмжиж Өмнөдэлгэр брэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэн нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Цаашилбал тус сумын нутаг дэвсгэрт буй байгалийн үзэсгэлэнт газар, тэр дундаа Балдан Врайбүн хийд, Хангал нуурийн байгалийн цогцолборт тулгуурлан монгол ахуй, уламжлалыг сурталчилах түгээн дэлгэрүүлэх зорилгоор орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого барин ажиллах төлөвлөгөөтэй байна.

Танилцуулга материал бэлтгэсэн:

НБТүшмэл М.Оюунтунгалаг